

**“БОР-ӨНДӨР” УБҮ-ИЙН ЗАХИРГААНЫ БАРИЛГЫН АГААРЖУУЛАЛТ, ГАЛЫН
ДОХИОЛОЛЫН СИСТЕМИЙН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ДААЛГАВАР**

Дугаар: МРЦМ/20250603074

Бор-Өндөр сум

1	Зураг, төсөв боловсруулах үндэслэл	“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө.
2	Захиалагч байгууллага	“Эрдэнэс критикал минералс” Төрийн өмчит үйлдвэрийн газар, “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэр
3	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	Бор-Өндөр сум, Бор-өндөр УБҮ-ийн захиргааны байр
4	Зураг, төсөв боловсруулах үе шат, хугацаа	- Ажлын зураг төсөл - Ажлын төсөв - Гэрээнд заасан хугацаанд
5	Зураг төслийн гүйцэтгэгч байгууллага	Сонгон шалгаруулалтаар эрх олгосон байгууллага
6	Ажиллах горим	Байнгын ажиллагаатай
7	Хийгдэх засварын зураг төсөл	- Агаар өгөх болон сорох механик систем төлөвлөх. - Одоо байгаа агааржуулалтын хоолой, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн солих. - Стандартын дагуу зарлан мэдээллэх систем бүхий утаа мэдрэгчтэй галын дохиололын систем төлөвлөх. - Галын дохиололын систем нь гал гарсан байршилыг заах нэгдсэн системд холбогдсон, хянах боломжтой байх.
8	Зориулалт хүчин чадал	Захиргаа удирдлагын хэсгийн оффиссын зориулалттай 5 давхар барилга. - Захиргааны байрны схем зураг /Зураг хавсаргах/
9	Барилгын үндсэн бүтээц, материал	Хана: Дүүргэлттэй бетонон хийц Дээвэр: Хавтгай дээвэр Хаалга цонх: Вакум цонх, модон хаалга Агаар сэлгэлт, галын дохиоллын тоног төхөөрөмж шугам хоолой: Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дотоодын болон олон улсын стандартын шаардлагад нийцсэн байх.
10	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр / Дулаан, усан хангамж ариутгах татуурга, цахилгаан холбоо, инженерийн	Цахилгаан: Төвийн шугам сүлжээ Дулаан: Төвийн шугам сүлжээ Ус хангамж: Төвийн шугам сүлжээ Ариутгах татуурга: Төвийн шугам сүлжээ

	хангамж/	
11	Ажлын зураг, төсөв боловсруулахад ашиглах материал	Монгол улсын хуулиуд: - Гамшгаас хамгаалах тухай хууль - Галын аюулгүй байдлын тухай хууль - Барилгын тухай хууль Норм, нормативууд: - Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал (БНБД 21-01-02); - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм (БНБД 21-02-02); - Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл (БНБД 21-04-05); - Халаалт агаар сэлгэлт ба кондиционер норм (БНБД 41-01-11) Стандартууд: - MNS 4244:94 Галын аюулгүй байдал.
12	Ажлын зураг төслийн бүрдэл	Гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсны дараа тухайн барилгын захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцөж нэмэлт санал авна. Баримт бичгийн бүрдэл: ○ Онцгой байдлын дүгнэлт ○ Магадлалын ерөнхий дүгнэлт Зургын иж бүрдэл: ○ Тайлбар бичиг ○ Халаалт агаар сэлгэлтийн засварын ажлын зураг төсөл ○ Галын дохиололын ажлын зураг ○ Төсөв ○ Ажлын тоо хэмжээ Захиалагчид хүлээлгэн өгөх баримт бичгийн шаардлага: ○ Хэвлэмэл байдлаар эх хувиас гадна 2 хувь хуулбар ○ CD Байдлаар 3 хувь захиалагчид хүлээлгэн өгнө ○ Баримт бичиг, ажлын зураг, төсвийг өнгөтөөр .pdf форматаар 300 dpi нягтралтай сканердаж flash-нд хавсаргах
13	Эдийн засгийн тооцоо төсөв.	Эдийн засгийн тооцоо болон төсвийн БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцно.
14	Онцгой нөхцөл	- Агааржуулалтын хоолойн гол түүхий эд болох цайрдсан нимгэн төмрийг материалын чанарт тавигдах шаардлагыг үндэслэн сонгон авч хэрэглэнэ. - Галын дохиололын систем нь мэдрэгчийн байршлыг илрүүлэх удирдлагын системтэй байх.